



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 440

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын  
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол-Солонгосын Политехник коллежийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй нийт 11,995,000.00 (арван нэгэн сая есөн зуун ерэн таван мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 2 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Монгол-Солонгосын Политехникийн коллежийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Цэгмид нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн саягтын хамт Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэст ирүүлэх.


3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн  
440 дугаар тооллын хавсралт

Монгол-Солонгосын Политехник коллежийн үндсэн хөрөнгөд  
бүртгэлтэй нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашин

Д/А	Автомашинны марк, улсын дугаар, арал	Үндэслэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт/км	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Сарсан босголт (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)	Дэнчингийн хэмжээ. (төгрөг)
1	Дайхану Триос, 74-87 УБЦ, арал № 1100019930	1998/ 2007	220000	7,600,000.00	7,600,000.00	0	0	500,000.00	125,000.00
2	Асно Комби, 94-77 УБВ, арал № KN2DAM2CISK005404	1996/ 2007	90263	4,395,000.00	4,395,000.00	0	0	500,000.00	125,000.00
	Нийт дүн			11,995,000.00 /арван нэгэн сая есөн зуун ерэн таван мянган/	11,995,000.00 /арван нэгэн сая есөн зуун ерэн таван мянган/	0	0	1,000,000.00 /нэг сая/	250,000.00 /хоёр зуун тавин мянган/